



САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
АХЛАХ ШИНЖЭЭЧ Н.ХУЛАНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ/

ХЯНАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

/Ц.АРИУНСАНАА/

ТАЙЛАГНАСАН:

ТӨСВИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ

/Н.ХУЛАН/

Тэмдэг

.....

(огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ
НЯМЖАВЫН ХУЛАНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
Зорилт 6.1. Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих								
6.1	Арга хэмжээ 6.1.2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцийн 2025 оны төсвийн хязгаарт тусгуулах урсгал болон хөрөнгө оруулалтын саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлнэ.	ШҮҮ1:хугацаа /2025 оны төсвийн хязгаар, 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөл/	Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын төсвийн хязгаарын саналыг нэгтгэн 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг нэгтгэн 2023 оны 08 дугаар	Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, ТЕЗ-ийн багцийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн 2024 оны 07 дугаар сарын	1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2025 оны төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулан ажилласан бөгөөд урсгал зардалд 24,9 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 872,0 тэрбум төгрөг, гадаад зээл тусламжаар хэрэгжүүлж буй төслүүдэд шаардагдах 341,4 тэрбум төгрөг буюу нийт 1 их наяд 292,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1851 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /ТЕЗ/-ын багцийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн		2024.05.15 2024.07.25	97

			сарын 15-ны өдөр хүргүүлсэн.	25-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлнэ.	боловсруулсан бөгөөд урсгал зардалд 76,5 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 1 их наяд 324,7 тэрбум төгрөг, гадаад зээл тусламжаар хэрэгжүүлж буй төслүүдэд шаардагдах 563,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/12 дугаартай албан бичгээр Сангийн яаманд, 01/14 дугаартай албан бичгээр УИХ-д, 01/13 дугаартай албан бичгээр ҮАГ-т тус тус хүргүүлсэн. 3. Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны 03/6387 дугаартай албан бичгийн дагуу Засгийн газрын 2024 оны 93 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам"-ын 1.5.4-т заасан "Олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах" хэлбэрийг сонгож Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлсэн ТЭЗ-ийн төсвийн төслийг яамны цахим хуудас болон facebook хаягаар https://www.facebook.com/mon.gov.mn/ линкээр байршуулан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд санал асуулга авч холбогдох тайланг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03/251 дугаартай албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.		
6.1	Арга хэмжээ 6.1.5: МУ-ын 2024 оны төсвийн тухай жуулиар хөрөнгө оруулалтын жагсаалтад багц	ШҮ1:Батлагдсан тушаал;	Барилга, хот байгуулалтын сайдын 11 тушаал батлуулсан.	Барилга, хот байгуулалтын сайдын 9 тушаал батлуулна.	1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан шинээр хэрэгжүүлэх 62,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 27,5 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 29		

дүнгээр тусгагдсан төсөл, арга хэмжээний задаргаа болон аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулан, батлуулж холбогдох байгууллагад хүргүүлдэг.			төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын дагуу боловсруулж, аймаг, нийслэлийн Засаг даргад "Эрх шилжүүлэх тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/02; 2. Шилжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад ерөнхий нэрээр тусгагдсан 273,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 109,1 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 8 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 48 төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулан "Жагсаалт батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/12; 3. Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад ерөнхий нэрээр тусгагдсан 92,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 30,0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 2 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 8 төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулан "Жагсаалт батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/15, уг тушаалыг хүчингүй болгон 122,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 38,0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 3 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 18 төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн боловсруулсан "Жагсаалт шинэчлэн батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/88; 4. Засгийн газрын 2023 оны 480, 2024 оны 26 дугаар дугаар тогтоолуудын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн	2024.01.02 2024.10.18	97
---	--	--	---	----------------------------------	-----------

				төсөл, арга хэмжээний "Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/33, А/42; 5. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 57 дугаар тогтоолын дагуу 2023 онд зохицуулалт хийгдсэн 340,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 129,4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 12 төсөл, арга хэмжээний "Хөрөнгийн зохицуулалт хийх тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/43, 6. Зохицуулалт хийгдсэнтэй холбогдуулан шилжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад ерөнхий нэрээр тусгагдсан 273,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 106,0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 8 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 48 төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн боловсруулан "Жагсаалт батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/44; 7. МУ-ын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан БХБСайдын 2024 оны 88 дугаар тушаалыг хүчингүй болгож шинээр хэрэгжүүлэх 122,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 53,0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 3 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 18 төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн боловсруулсан "Жагсаалт батлах тухай" Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 71 дугаартай буюу нийт дээр дурдсан 9	
--	--	--	--	--	--

					тушаалыг тус тус батлуулж журамд заасны дагуу хугацаанд нь Сангийн яам болон холбогдох аймаг, нийслэл, харъяа байгууллагад албан бичгээр хүргүүлсэн.		
Зорилт 6.4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах							
6.4	Арга хэмжээ 6.4.1: Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төсөл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулах.	ШҮ1:Хэрэгжилт хувь ШҮ2:Шилэн дансанд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд буюу сар, улирал, жилээр оруулсан байх	2023 онд шилэн дансанд байршуулсан мэдээний тоо-26; Хэрэгжилтийн хувь-100%	2024 онд шилэн дансанд байршуулах мэдээний тоо-26; Хэрэгжилтийн хувь 95-100%	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг 1 удаа, дараа жилийн төсвийн төслийг 1 удаа, тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 12 удаа, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 12 удаа сар бүр шилэн дансанд тогтмол мэдээллэн хугацаанд нь байршуулсан.	2024.01.01 2024.12.08	98

Нэмэлт арга хэмжээний биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон үнэлгээний хороонд ажиллан, үйл явц, үр дүнг тогтмол тайлагнах	ШҮ1: Ажлын хэсгийн тоо ШҮ2: Ажлын хэсгийн гүйцэтгэл, үр дүн	Ажлын хэсгийн тоо-1, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалтыг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 1/2035 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн.	Ажлын хэсэг, үнэлгээний хорооны тоо-3, Хэрэгжилтийн хувь-90-100%	1. ТНБД-ын 2023 оны А/70 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд барилга, хот байгуулалтын салбарын чиглэлээр тусгуулах саналыг нэгтгэх боловсруулах ажлын хэсэгт ажилласан. 2. ТНБД-ын 2024 оны А/12, А/15 дугаар тушаалуудаар байгуулагдсан үнэлгээний хороонд гишүүнээр томилогдон холбогдох тендерийн үнэлгээг тухай бүр хийж, үнэлгээний дүгнэлтэд саналаа өгч ажилласан. 3. ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу 2024.04.04-2024.04.06-ны өдрүүдэд Хэнтий аймагт томилолтоор ажиллан холбогдох тайланг танилцуулсан. 4. ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу 2024.10.21-2024.10.25-ны өдрүүдэд Төв, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгийн нийт 6 суманд	2024.01.01 2024.12.20	95


				томилолтоор холбогдох танилцуулсан.	ажиллан тайланг		
2	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг гарган дүгнүүлэх, хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох тушаал шийдвэрийн биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гарган танилцуулах	ШҮ1: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ШҮ2: Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	Хэрэгжилт-97%	Хэрэгжилтийн хувь-90-100%	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, хариуцсан чиг үүргийн дагуу ЗГ-ын тогтоолын төслүүдэд өгөх санал /нийт 49/, Хот, байгуулалт, орон сууцжуулалтын сайдын тушаалын төсөл боловсруулалт, баталгаажуулалт /нийт 9/, ТЕЗ-ийн төсвийн хязгаар, төсвийн төсөл болон хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбогдох шаардлагатай мэдээллийг тухай бүр хугацаанд нь гарган ажилласан.	2024.01.01 2024.12.20	95
3	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	ШҮ1: Ирсэн явсан албан бичгийн тоо ШҮ2: Албан бичгийн шийдвэрлэлт	Нийт 202 албан бичгийг хугацаанд нь судлан танилцуулж, шийдвэрлэсэн. 28 материал архивт хүлээлгэн өгсөн.	Хэрэгжилтийн хувь-100%	Холбогдох хууль, журам, зааврын дагуу тайлант хугацаанд ирсэн нийт 156 албан бичгийг хугацаанд нь судлан танилцуулж, шийдвэрлэсэн.	2024.01.01 2024.12.20	95

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдаж буй холбогдох сургалтуудад хамрагдах	Сангийн яам болон холбогдох байгууллагаас зохион байгуулах төсвийн төлөвлөлттэй холбогдох сургалт семинарт хамрагдана.	4 удаа	2 удаа	1. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас 2024 оны 01 дүгээр 18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт" сургалт; 2. Сангийн яамнаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба цахим систем" сургалт; 3. Удирдлагын академиас 2024 оны 04 дүгээр 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын шинжилгээ" сургалтад тус тус хамрагдсан.	2024.01.01 2024.12.20	95

ТАЙЛАН ГАРГАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Н.ХУЛАН



2024 оны 12 сарын 20 өдөр

(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

(Огноо)